



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Сэлэнгэ аймгийн Баруунбүрэн сумын нэгдүгээр цэцэрлэгийн 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Аудитын код: СЭА-2024/226-НА-СТА-ТШЗ

<p>Цахим хуудас: www.selenge@audit.gov.mn</p> <p>Сүхбаатар сум 2024 он</p>	<p>Дарга, тэргүүлэх аудитор: Ч.Энхтуяа Утас: 70363040 Цахим хаяг: enkhtuyach@audit.gov.mn</p> <p>Аудитын менежер: Б.Батмөнх Утас: 70363036 Цахим хаяг: batmunkhb@audit.gov.mn</p> <p>Аудитын гүйцэтгэсэн: Мэдээлэл Аудит ХХК-ийн Сэлэнгэ салбар Утас: 99499667 Цахим хаяг: infoauditselenge@gmail.com</p>
--	--

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

АГУУЛГА

1. Аудитын дүгнэлт.....	3-4
2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл	5-9
3. Санхүүгийн тайлангийн тодруулга.....	10
3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа	10
3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин.....	11
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал.....	11
3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлт.....	11
3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв.....	12-13
4. Аудитын тайлан.....	14
4.1 Ерөнхий зүйл	14
4.2 Материаллаг байдал	15
4.3 Төрийн хэмнэлтийн хуулийн хэрэгжилт.....	15
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	15
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	16
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал	17
5. Аудитын илрүүлэлт	17
6. Аудитаар илэрсэн буруу илэрхийллийн нэгтгэл	18-19

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
БШУЯ	Боловсрол, шинжлэх ухааны яам
БШУС	Боловсрол, шинжлэх ухааны сайд
БШУГ	Боловсрол, шинжлэх ухааны газар
ЗГ	Засгийн газар
НДШ	Нийгмийн даатгалын шимтгэл
ИТХ	Иргэдийн төлөөлөгчдийн хурал



СЭЛЭНГЭ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

II баг, Цагаан эрэг, Сүхбаатар сум,
Сэлэнгэ аймаг, 43081
Утас/Факс: (976)-7036-3040
Цахим шуудан: Selenge@audit.gov.mn
Цахим хуудас: www.audit.mn

Б А Р У У Н Б Ü Р Э Н С У М Ы Н Н Э Г Д Ü Г Э Э Р
Ц Э Ц Э Р Л Э Г И Й Н Э Р Х Л Э Г Ч И Й Н
Y Y Р Г И Й Г Т Y Р О Р Л О Н Г Y И Ц Э Т Г Э Г Ч
Б.ГЭРЭЛТУЯА ТАНАА

2024.02.23 № СЭА-2024/226-НА-СТА-ТШЗ
танай _____-ны № _____-т

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Сэлэнгэ аймгийн Баруунбүрэн сумын нэгдүгээр цэцэрлэгийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Баруунбүрэн сумын нэгдүгээр цэцэрлэгийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Тайлант онд сумын хөрөнгө оруулалтаар 20,000.0 мянган төгрөгийн гадна талбайн тоглоомууд, БШУЯ-аас 176,854.8 мянган төгрөгийн ариун цэврийн байгууламжийг үнэ төлбөргүйгээр хүлээн авсан байна.

Баруунбүрэн сумын нэгдүгээр цэцэрлэг нь Боловсролын Ерөнхий газрын даргын 2023 оны 10 дугаар сарын 10-ны өдрийн А/324 дүгээр тушаалаар сургалтын байгууллагын гүйцэтгэлийн үнэлгээний үр дүнгээр 3 дугаар түвшинд үнэлэгдэж, урамшуулалд 10,060.0 мянган төгрөгийн санхүүжилт авч зарцуулсан байна.

Аудитын гол асуудал

Нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаанд мөрдөж байгаа Боловсрол, Шинжлэх Ухааны сайдын 2021 оны 01 дүгээр сарын 26-ны өдрийн А/22 дугаар тушаалаар баталсан "Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг" нь гүйцэтгэл, үр дүнгээр санхүүжиж байгаа байгууллагын онцлогт тохироогүй, үр дүнд

суурилсан төсөвлөлт, санхүүжилт, хөрөнгө оруулалт, хөтөлбөр, арга хэмжээний бүртгэлийн талаар нарийн тусгаагүй байна.

Байгууллагын төсөв, санхүүжилтийг зардлын эдийн засгийн ангиллаар нь бус “бараа үйлчилгээний бусад зардал” гэсэн ангиллаар бөөнд нь тусган, төлөвлөж, баталж байгаа нь төсвийг зардлын бүлэг, зүйлээр төлөвлөж, зарцуулах, зарцуулалтад хяналт тавих зарчмыг алдагдуулж байна.

Бусад асуудлын хэсэг

Байгууллагын удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ.

Тус цэцэрлэг нь 2023 оны “Гүйцэтгэлийн төлөвлөгөө”-нд тусгагдсан 7 зорилтын хүрээнд 6 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөж, 90.8 хувийн гүйцэтгэлтэй үнэлэгдсэн байна.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.


Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ч.ЭНХТУЯА

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	63,796,562.04	138,723,760.91
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	9,475,176.46	75,104,610.93
31200	Банкинд байгаа бэлэн мөнгө	9,475,176.46	75,104,610.93
31210	Төгрөг	9,475,176.46	75,104,610.93
31211	Төрийн сангийн харилцах	9,475,176.46	75,104,610.93
35	БАРАА МАТЕРИАЛ	54,321,385.58	63,619,149.98
35100	Түүхий эд материал	80,600.00	80,600.00
35130	Эм боох материал	80,600.00	80,600.00
35400	Хангамжийн материал	54,240,785.58	63,538,549.98
35410	Бичиг хэргийн материал	1,278,190.00	845,350.00
35420	Аж ахуйн материал	48,988,217.98	49,938,967.98
35460	Хүнсний материал	3,974,377.60	12,754,232.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	697,344,152.42	868,724,686.39
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	697,344,152.42	868,724,686.39
39200	Биет хөрөнгө	686,018,818.98	857,649,352.91
39201	Барилга, байгууламж, орон сууц	695,278,885.00	872,133,691.00
39202	Хуримтлагдсан элэгдэл	(72,317,070.51)	(93,093,824.43)
39205	Машин тоног төхөөрөмж(компьютер)	35,889,885.90	30,408,382.00
39206	Хуримтлагдсан элэгдэл	(19,643,031.41)	(17,604,476.67)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	38,778,658.03	58,043,264.03
39208	Хуримтлагдсан элэгдэл	(13,018,770.83)	(12,012,944.02)
39214	Бусад үндсэн хөрөнгө	24,965,469.00	24,965,469.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	(5,100,007.20)	(6,375,009.00)
39217	Ном	1,184,801.00	1,184,801.00
39300	Биет бус хөрөнгө	11,325,333.44	11,075,333.48
39301	Програм хангамж	1,250,000.00	1,250,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(666,666.56)	(916,666.52)
39303	Бусад биет бус хөрөнгө	10,742,000.00	10,742,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	761,140,714.46	1,007,448,447.30
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	1,266,126.25	-
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	1,266,126.25	-
41300	Өглөг	1,266,126.25	-
41310	Ажилчидтай холбогдсон өглөг	1,266,126.25	-
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	759,874,588.21	1,007,448,447.30
51	Засгийн газрын хувь оролцоо	759,874,588.21	1,007,448,447.30
51100	Засгийн газрын оруулсан капитал	79,821,603.00	79,821,603.00
511002	Орон нутгийн төсвийн оруулсан хөрөнгө	79,821,603.00	79,821,603.00
51200	Хуримтлагдсан үр дүн	292,742,326.57	540,316,185.66
51210	Өмнөх үеийн үр дүн	(467,132,261.64)	292,742,326.57
51220	Тайлант үеийн үр дүн	759,874,588.21	247,573,859.09
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	387,310,658.64	387,310,658.64
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	761,140,714.46	1,007,448,447.30

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	1,293,758,895.69	922,804,706.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	772,218,163.85	196,854,806.00
120	Нийтлэг татварын бус орлого	772,218,163.85	196,854,806.00
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Үндсэн хөрөнгө	725,887,717.28	196,854,806.00
120018	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Бараа материал	46,330,446.57	-
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	521,540,731.84	725,949,900.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	433,124,200.00	626,645,800.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	433,124,200.00	626,645,800.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	88,416,531.84	99,304,100.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	88,416,531.84	99,304,100.00
II	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	533,884,307.48	675,230,846.91
21	УРСГАЛ ЗАРДАЛ	533,884,307.48	675,230,846.91
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	525,605,407.48	668,691,846.91
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	332,494,882.82	413,534,256.64
210101	Үндсэн цалин	250,625,381.36	290,818,087.42
210102	Нэмэгдэл	75,026,253.03	105,359,297.22
210104	Урамшуулал	6,843,248.43	17,356,872.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	42,877,843.88	52,654,582.64
210201	Тэтгэврийн даатгал	29,442,060.66	35,909,943.08
210202	Тэтгэмжийн даатгал	3,452,449.88	4,241,908.17
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,671,239.98	3,388,328.77
210204	Ажилгүйдлийн даатгал	664,735.88	954,273.56
210205	Эрүүл мэндийн даатгал	6,647,357.48	8,160,129.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	62,422,105.43	83,881,800.00
210301	Гэрэл, цахилгаан	6,266,105.67	9,769,195.84
210302	Түлш, халаалт	52,279,999.76	68,040,604.16
210303	Цэвэр, бохир ус	3,876,000.00	6,072,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	4,248,709.59	-
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	205,300.00	-
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	4,000.00	-
210408	Бараа материал ақталсны зардал	4,039,409.59	-
2105	Нормативт зардал	43,050,000.90	52,740,395.60
210502	Хоол, хүнс	43,050,000.90	52,740,395.60
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	311,000.00	15,562,300.00
210604	Урсгал засвар	311,000.00	15,562,300.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	731,999.99	720,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	731,999.99	720,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	39,468,864.87	49,598,512.03
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	7,062,240.00	20,003,990.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	3,335,560.00	599,250.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	29,071,064.87	28,995,272.03
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	8,278,900.00	6,539,000.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	8,278,900.00	6,539,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	8,278,900.00	6,539,000.00
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)	759,874,588.21	247,573,859.09
VI	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)	759,874,588.21	247,573,859.09

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)	521,540,731.84	725,949,900.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	521,540,731.84	725,949,900.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	433,124,200.00	626,645,800.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	433,124,200.00	626,645,800.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	88,416,531.84	99,304,100.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	88,416,531.84	99,304,100.00
II	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	511,475,555.38	656,799,465.53
21	УРСГАЛ ЗАРДАЛ	511,475,555.38	656,799,465.53
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	503,196,655.38	650,260,465.53
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	331,324,992.82	414,149,792.20
210101	Үндсэн цалин	249,455,491.36	288,673,016.10
210102	Нэмэгдэл	75,026,253.03	106,950,013.40
210104	Урамшуулал	6,843,248.43	18,526,762.70
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	42,781,607.63	53,305,173.33
210201	Тэтгэврийн даатгал	29,345,824.41	36,287,618.83
210202	Тэтгэмжийн даатгал	3,452,449.88	4,256,056.42
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,671,239.98	3,440,248.07
210204	Ажилгүйдлийн даатгал	664,735.88	847,716.10
210205	Эрүүл мэндийн даатгал	6,647,357.48	8,473,533.91
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	62,422,105.43	83,881,800.00
210301	Гэрэл, цахилгаан	6,266,105.67	9,769,195.84
210302	Түлш, халаалт	52,279,999.76	68,040,604.16
210303	Цэвэр, бохир ус	3,876,000.00	6,072,000.00
2105	Нормативт зардал	46,717,349.50	61,520,250.00
210502	Хоол, хүнс	46,717,349.50	61,520,250.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	490,000.00	15,422,300.00
210604	Урсгал засвар	490,000.00	15,422,300.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	962,000.00	720,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	962,000.00	720,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	18,498,600.00	21,261,150.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	14,888,600.00	18,246,150.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	3,610,000.00	3,015,000.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	8,278,900.00	6,539,000.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	8,278,900.00	6,539,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	8,278,900.00	6,539,000.00
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	10,065,176.46	69,150,434.47
V	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)	590,000.00	3,521,000.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	590,000.00	3,521,000.00
2200	Дотоод эх үүсвэрээр	590,000.00	3,521,000.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	590,000.00	3,521,000.00
VI	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)	(590,000.00)	(3,521,000.00)
VIII	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)	9,475,176.46	65,629,434.47
101	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	9,475,176.46
20	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	9,475,176.46	75,104,610.93

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
1	2021 оны 12-р сарын 31-нээрс үлдэгдэл	-	-	-	-
2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	79,821,603.00	387,310,658.64	(467,132,261.64)	-
3	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	79,821,603.00	387,310,658.64	(467,132,261.64)	-
4	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	-	-	-	-
5	Үндсэн хөрөнгийн өсөлт бууралт	-	-	-	-
6	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	-	-	-	-
7	Өмчид гарсан өөрчлөлт	-	-	-	-
8	Зарласан ногдол ашиг	-	-	-	-
9	Тайлант үеийн үр дүн	-	-	759,874,588.21	759,874,588.21
10	2022 оны 12-р сарын 31-нээрс үлдэгдэл	79,821,603.00	387,310,658.64	292,742,326.57	759,874,588.21
11	2023 оны 1-р сарын 1-нээрс үлдэгдэл	79,821,603.00	387,310,658.64	292,742,326.57	759,874,588.21
12	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	-	-
13	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	79,821,603.00	387,310,658.64	292,742,326.57	759,874,588.21
14	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	-	-	-	-
15	Үндсэн хөрөнгийн өсөлт бууралт	-	-	-	-
16	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	-	-	-	-
17	Өмчид гарсан өөрчилөлт	-	-	-	-
18	Зарласан ногдол ашиг	-	-	-	-
19	Тайлант үеийн үр дүн	-	-	247,573,859.09	247,573,859.09
20	2023 оны 12-р сарын 31-нээрс үлдэгдэл	79,821,603.00	387,310,658.64	540,316,185.66	1,007,448,447.30

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Төсвийн гүйцэтгэлийн тайлан	Гүйцэтгэлийн зөрүү/хэтрэлт, хэмнэлт/	Хувь
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	735,425,100.00	660,320,465.53	75,104,634.47	89.8
21	УРСГАЛ ЗАРДАЛ	735,425,100.00	660,320,465.53	75,104,634.47	89.8
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	728,886,100.00	653,781,465.53	75,104,634.47	89.7
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	474,816,400.00	414,149,792.20	60,666,607.80	87.2
210101	Үндсэн цалин	331,133,100.00	288,673,016.10	42,460,083.90	87.2
210102	Нэмэгдэл	128,798,100.00	106,950,013.40	21,848,086.60	83.0
210104	Урамшуулал	14,885,200.00	18,526,762.70	(3,641,562.70)	124.5
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	63,724,400.00	53,305,173.33	10,419,226.67	83.6
210201	Тэтгэврийн даатгал	43,332,500.00	36,287,618.83	7,044,881.17	83.7
210202	Тэтгэмжийн даатгал	5,098,200.00	4,256,056.42	842,143.58	83.5
210203	ҮОМШӨ-ний даатгал	4,078,300.00	3,440,248.07	638,051.93	84.4
210204	Ажилгүйдлийн даатгал	1,019,700.00	847,716.10	171,983.90	83.1
210205	Эрүүл мэндийн даатгал	10,195,700.00	8,473,533.91	1,722,166.09	83.1
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	83,881,800.00	83,881,800.00	-	100.0
210301	Гэрэл, цахилгаан	9,467,000.00	9,769,195.84	(302,195.84)	103.2
210302	Түлш, халаалт	69,096,400.00	68,040,604.16	1,055,795.84	98.5
210303	Цэвэр, бохир ус	5,318,400.00	6,072,000.00	(753,600.00)	114.2
2105	Нормативт зардал	64,651,200.00	61,520,250.00	3,130,950.00	95.2
210502	Хоол, хүнс	64,651,200.00	61,520,250.00	3,130,950.00	95.2
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	15,422,300.00	15,422,300.00	-	100.0
210604	Урсгал засвар	15,422,300.00	15,422,300.00	-	100.0
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,006,000.00	720,000.00	286,000.00	71.6
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	1,006,000.00	720,000.00	286,000.00	71.6
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	25,384,000.00	24,782,150.00	601,850.00	97.6
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	22,366,000.00	21,767,150.00	598,850.00	97.3
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	3,018,000.00	3,015,000.00	3,000.00	99.9
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	6,539,000.00	6,539,000.00	-	100.0
2132	Бусад урсгал шилжүүлэг	6,539,000.00	6,539,000.00	-	100.0
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	6,539,000.00	6,539,000.00	-	100.0
III	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	735,425,100.00	725,949,900.00	9,475,200.00	98.7
31	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	626,645,800.00	626,645,800.00	-	100.0
310001	Улсын төсвөөс санхүүжих	626,645,800.00	626,645,800.00	-	100.0
32	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	99,304,100.00	99,304,100.00	-	100.0
320001	Орон нутгийн төсвөөс	99,304,100.00	99,304,100.00	-	100.0
35	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	9,475,200.00	-	9,475,200.00	-
350003	Урьд оны үлдэгдлээс санхүүжих	9,475,200.00	-	9,475,200.00	-
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	9,475,176.46	(9,475,176.46)	-
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	75,104,610.93	(75,104,610.93)	-

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Сэлэнгэ аймгийн Баруунбүрэн сумын нэгдүгээр цэцэрлэг нь “Хамтын оролцоо, үнэлгээний үр дүнд суурилан цэцэрлэгийн менежментийг сайжруулж, боловсролын үйлчилгээний хүртээмж, чанарт ахиц гаргах” гэсэн эрхэм зорилгын хүрээнд үйл ажиллагаагаа явуулсан байна.

Үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- Эцэг эх асран хамгаалагч нарт цэцэрлэгийн үйл ажиллагааг танилцуулах, оролцоог нэмэгдүүлэх,
- Бага насны хүүхдийг амьдралын арга барилд сургах, дадал хэвшилд сургах,
- Номын сангийн үйлчилгээг, сургах үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх, нээлттэй байдлаар хангах,
- Хүүхэд бүрийн онцлог ялгаатай байдлыг илрүүлэх, тэгш боловсролыг эзэмшүүлэх, сурлагын хоцрогдлыг арилгах, сурлагын ахиц гаргах.

3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

- *Боловсролын ерөнхий хууль 2023 оны 7 дугаар сарын 7-нд батлагдсан,*
- *Монгол Улсын 2023 оны Төсвийн тухай хуулиар төсөв, санхүүжилттэй холбоотой,*
- *Хөдөлмөрийн тухай хуульд 2023 оны 07 дугаар сарын 07-нд нэмэлт өөрчлөлт орсон,*
- *Төрийн хэмнэлтийн тухай хуульд 2023 оны 06 дугаар сарын 16, 07 дугаар сарын 07-нд нэмэлт өөрчлөлт орсон,*
- *Төрийн албаны тухай хуульд 2023 оны 01 дүгээр сарын 06, 05 дугаар сарын 04, 06 дугаар сарын 16, 07 дугаар сарын 07, 11 дүгээр сарын 10, 12 дугаар сарын 07-нд нэмэлт өөрчлөлт орсон,*
- *Засгийн газрын 2023 оны 06 дугаар сарын 21-ний өдрийн 241 дүгээр тогтоолоор төрийн албаны зарим албан тушаалын цалингийн сүлжээ, доод хэмжээг шинэчлэн тогтоосон,*
- *БШУС-ын 2023 оны 06 дугаар сарын 13-ны өдрийн 1/2714 тоот албан бичгээр боловсролын байгууллагын төсвийн шинэчлэлийн хүрээнд 1."ЕБС-д сургалтын тоног төхөөрөмжийн нөхөн хангалт шийдвэрлэх", 2."Цэцэрлэгт шаардлагатай хүүхдийн тоглоом, наадгай, зөөлөн эдлэл ханган нийлүүлэх, худалдан авах ажиллагааг зохион байгуулах" чиглэлийг хүргүүлсэн гэх мэт,*

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналт, үйл ажиллагааны зохион байгуулалтын хэрэгжилт үр нөлөөтэй гэж үзлээ.

Тайлант онд тус газрын санхүүгийн үйл ажиллагаанд БШУЯ-ны Хяналт, шинжилгээ үнэлгээний газрын Дотоод аудитын хэлтсээс хяналт, шалгалт хийгдээгүй боловч сар бүрийн төсвийн гүйцэтгэлийн мэдээ, шилэн дансны мэдээллээр дамжуулан дотоод хяналт, шалгалтыг хэрэгжүүлсэн байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Баруунбүрэн сумын нэгдүгээр цэцэрлэгийн 2023 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Баруунбүрэн сумын нэгдүгээр цэцэрлэг нь Боловсрол, Шинжлэх Ухааны сайдын 2021 оны 01 дүгээр сарын 26-ны өдрийн А/22 дугаар тушаалаар баталсан Боловсрол, Шинжлэх Ухааны салбарын төсвийн ерөнхийлөн захирагчийн харьяа төсөвт байгууллагуудад мөрдөгдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг үйл ажиллагаандаа ашиглаж байна.

Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн хэдий ч гүйцэтгэл, үр дүнгээр санхүүжиж байгаа байгууллагын онцлогт тохироогүй, үр дүнд суурилсан төсөвлөлт, санхүүжилт, хөрөнгө оруулалт, хөтөлбөр, арга хэмжээний бүртгэлийн талаар нарийн тусгаагүй байна.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Баруунбүрэн сумын нэгдүгээр цэцэрлэгийн 2023 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан “Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар”-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 246,307.7 мянган төгрөгөөр буюу 32.0 хувиар өссөн байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	9,475.2	75,104.6	65,629.4
Авлага	-	-	-
Бараа материал	54,321.4	63,619.1	9,297.7
Үндсэн хөрөнгө	697,344.1	868,724.7	171,380.6
Нийт хөрөнгө	761,140.7	1,007,448.4	246,307.7
Өр төлбөр	1,266.1	-	(1,266.1)
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	759,874.6	1,007,448.4	247,573.8
Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн	761,140.7	1,007,448.4	246,307.7

Дээрх хүснэгтээс харахад дараах дансанд нөлөө бүхий өөрчлөлт гарсан байна. Үүнд:

1. Мөнгөн хөрөнгө дансны үлдэгдэл 75,104.6 мянган төгрөг болж 65,629.4 мянган төгрөгөөр өссөн нь зардлын хэмнэлттэй холбоотой бөгөөд уг хэмнэлтийг Төсвийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.9 дэх “Энэ хуулийн 7.7 дахь хэсэг эрүүл мэнд, боловсролын салбарын гүйцэтгэлд суурилсан санхүүжилтийн зарчмаар санхүүждэг байгууллагын төсвийн захирагчид хамаарахгүй” гэж заасны дагуу төрийн сангийн харилцах дансанд үлдэгдлээр тайлагнагдсанаас,
2. Бараа материалын дансны үлдэгдэл 63,619.1 мянган төгрөг болж 9,297.7 мянган төгрөгөөр өссөн нь төсвийн хөрөнгөөр 90,402.0 мянган төгрөгийн бараа материал худалдан авсан бөгөөд үйл ажиллагаанд 81,104.3 мянган төгрөгийн хөрөнгийг зарцуулснаас,
3. Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 868,724.7 мянган төгрөг болж 171,380.6 мянган төгрөгөөр өссөн нь орон нутгийн хөрөнгө оруулалтаар 20,000.0 мянган төгрөгийн гадна талбайн хүүхдийн тоглоом, улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хийгдсэн 176,854.8 мянган төгрөгийн ариун цэврийн байгууламжийг үнэ төлбөргүй хүлээн авч, сумын ИТХ-ын 2023 оны 11 сарын 29-ны өдрийн 82 дугаар тогтоолын дагуу цаашид ашиглах боломжгүй 9,737.9 мянган төгрөгийн хөрөнгө акталснаас тус тус шалтгаалсан байна.

3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Сангийн яамны 2022 оны 02 дугаар сарын 28-ны “Чиглэл хүргүүлэх тухай” албан бичгээр байгууллагын нэмэлт санхүүжилтийн дансыг хааж, нэмэлт санхүүжилттэй холбоотой гүйлгээг урсгал дансаар дамжуулан гүйцэтгэж, тайланг төсвийн гүйцэтгэлийн тайланд нэгтгэсэн байна.

3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2023 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг улсын төсвөөс 736,263.1 мянган төгрөг, орон нутгийн төсвөөс 99,304.1

мянган төгрөг нийт 835,567.2 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж дээд шатны төсвийн захирагчид хүргүүлснээс улсын төсвийн санхүүжилтийг 100,142.1 мянган төгрөгөөр бууруулж 448,580.5 мянган төгрөгөөр, орон нутгийн төсвийн санхүүжилтийг 99,304.1 мянган төгрөгөөр, нийт 547,884.6 мянган төгрөгөөр баталсан байна.

Төсвийн жилийн дундуур улсын төсвийн санхүүжилтийг 187,540.5 мянган төгрөгөөр нэмэгдүүлж, нийт 636,121.0 мянган төгрөгийн, орон нутгийн төсвийн санхүүжилтийг 99,304.1 мянган төгрөгөөр нийт 735,425.1 мянган төгрөгөөр эцэслэн баталсан байна.

3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 7 арга хэмжээг санхүүжүүлэхээр улсын төсвөөс 636,121.0 мянган төгрөг, орон нутгийн төсвөөс 99,304.1 мянган төгрөг, нийт 735,425.1 мянган төгрөгийн санхүүжилт авч, урсгал үйл ажиллагаанд 660,320.5 мянган төгрөгийг зарцуулж, 75,104.6 мянган төгрөгийг хэмнэж үлдэгдлээр тайлагнасан байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 660,320.5 мянган төгрөг буюу 89.8 хувьтай байгаа нь боловсролын байгууллагын багш, ажиллагсдын мэргэжил дээшлүүлэх хөтөлбөрийг хэрэгжүүлэх зардлыг 177.0 мянган төгрөгөөр, нүүдлийн бүлэгт хамруулах хөтөлбөрийг хэрэгжүүлэх зардлыг 13,453.5 мянган төгрөгөөр, боловсролын стандарт сургалтын төлөвлөгөө, хөтөлбөрийг хэрэгжүүлэх зардлыг 43,851.3 мянган төгрөгөөр, сургалтын хэвийн үйл ажиллагааг хангах хөтөлбөрийн зардлыг 17,622.8 мянган төгрөгөөр тус тус хэмнэсэнтэй холбоотой байна.

Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

Хөтөлбөр, арга хэмжээ	Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл	/мянган төгрөгөөр/	
			Зөрүү	Биелэлт /хувиар/
Улсын төсвөөс санхүүжих	636,121.0	561,016.4	75,104.6	88.2
81605 - Эрүүл мэндийг дэмжих	1,509.0	1,509.0	-	100.0
81807 - Цэцэрлэгийн хүүхдийн хоол	60,790.2	60,790.2	-	100.0
81816 - Хүүхдэд ээлтэй сургалтын орчин	4,179.1	4,179.1	-	100.0
81823 - Боловсролын байгууллагын багш, ажиллагсдын мэргэжил дээшлүүлэх	1,509.0	1,332.0	177.0	88.3
81832- Нүүдлийн бүлэгт хамруулах	19,773.0	6,319.5	13,453.5	32.0
81834 - Боловсролын стандарт, сургалтын төлөвлөгөө, хөтөлбөрийг хэрэгжүүлэх	400,830.0	356,978.7	43,851.3	89.1
81835 - Сургалтын хэвийн үйл ажиллагааг хангах	147,530.7	129,907.9	17,622.8	88.1
Орон нутгийн төсвөөс санхүүжих	99,304.1	99,304.1	-	100.0
80111 - Төрийн өмчийн барилгын тогтмол зардал	99,304.1	99,304.1	-	100.0
ДҮН	735,425.1	660,320.5	75,104.6	89.8

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Сангийн яамны 2022 оны 02 дугаар сарын 28-ны “*Чиглэл хүргүүлэх тухай*” албан бичгээр байгууллагын нэмэлт санхүүжилтийн дансыг хааж, нэмэлт санхүүжилттэй холбоотой гүйлгээг урсгал дансаар дамжуулан гүйцэтгэж, тайланг төсвийн гүйцэтгэлийн тайланд нэгтгэсэн байна.

3.5.4 Худалдан авах ажиллагааны гүйцэтгэл

Жилийн худалдан авах ажиллагааны төлөвлөгөө боловсруулж, батлуулж, тайлагнаагүй, шууд худалдан авах босго үнээс давсан /2023 оны анх батлагдсан төсвөөр/ цэцэрлэгийн хүүхдийн хоолны 65,917.9 мянган төгрөгийн худалдан авах ажиллагааны сонгон шалгаруулалтыг цахимаар, нийтэд нээлттэй, ил тод зарлаж, гүйцэтгэгчийг шалгаруулалгүйгээр тухай бүр гэрээ байгуулж, худалдан авалтыг хийж, гүйцэтгэсэн байна.

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Баруунбүрэн сумын нэгдүгээр цэцэрлэгийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газартай байгуулсан гэрээний дагуу “Мэдээлэл аудит” ХХК-ийн шинжээч З.Азжаргал, чанарын хяналтыг салбарын захирал А.Гэрэлмаа гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер Б.Батмөнх, дарга, тэргүүлэх аудитор Ч.Энхтуяа нар тус тус хэрэгжүүлсэн.

Баруунбүрэн сумын нэгдүгээр цэцэрлэгийн 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Мэдээлэл аудит ХХК-д 2024 оны 01 дүгээр сарын 25-ны өдрийн 04 дүгээр албан бичгээр ирүүлсэн байна.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг дунд гэж үнэллээ.

Төлөвлөлтийн шатны материаллаг байдлыг 2022 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлын 533,884.3 мянган төгрөгөөс 1.5 хувиар буюу 8,008.3 мянган төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж, шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Баруунбүрэн сумын нэгдүгээр цэцэрлэг нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хүрээнд дараах арга хэмжээнүүдийг хэрэгжүүлсэн байна. Үүнд:

- Бичгийн цаас, принтерийн хорны зардлыг хэмнэх зорилгоор бичиг хэрэг, албан хэрэг хөтлөлтөд дотоод сүлжээг ашигласан,
- Шаардлагагүй бараа материалыг их хэмжээгээр авч нөөцлөөгүй,
- Хэвлэл захиалгын төлбөр гаргалгүй ажилласан зэрэг төсвийн шууд захирагчтай хамааралтай заалтуудыг мөрдөж, батлагдсан төсвийн хүрээнд ажилласан байна.

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд шилэн дансны нэгдсэн системийн мэдээлбэл зохих 28 төрлийн 159 мэдээллийг байршуулахаас 154 мэдээлэл байршуулан тухай бүр мэдээлэх 12 мэдээллийг хугацаа хоцроосон байна. Үүнд:

- Төсвийн байгууллагын батлагдсан төсөв, гүйцэтгэл, хэтрэлт хэмнэлтийн шалтгаан тайлбарын хамт- эдийн засгийн ангилал - 5 удаа,
- Төсвийн байгууллагын батлагдсан төсөв, гүйцэтгэл – Хөтөлбөр, зориулалт - 5 удаа,
- Байгууллагын батлагдсан орон тоонд орсон өөрчлөлт – 2 удаа

Шийдвэрлэсэн нь: Шилэн дансны цахим хуудаст мэдээлбэл зохих мэдээллийг хугацаанд нь мэдээлж байх зөвлөмжийг хүргүүлэхээр шийдвэрлэв.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцээгүй гэж дүгнэлээ.

4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Орон нутагт хүнсний бүтээгдэхүүний бөөний төвлөрсөн цэг байхгүй, зах зээл хомс шалтгаанаар үнийн харьцуулалт хийлгүйгээр “Бүрэн шувуут” ХХК, “Өгөөж бүрэн” ХХК, “Бүрэн сэлэнгэ өгөөж” ХХК-тай шууд гэрээ байгуулж худалдан авалтыг гүйцэтгэсэн нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1 дэх “Захиалагч тендерийн урилгыг үндэсний хэмжээний өдөр тутмын сонин, худалдан авах ажиллагааны цахим систем болон хэвлэл мэдээллийн бусад хэрэгслээр нийтэд зарлан мэдээлнэ” гэсэн заалтыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Худалдан авах ажиллагааг ил тод, өрсөлдөх тэгш боломжтой, үр ашигтай, хэмнэлттэй, хариуцлагатай байх зарчмыг баримталж зохион байгуулах зөвлөмж өгөх.

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.5.1 Завсрын аудитын талаар

“Мэдээлэл аудит” ХХК-ийн 2023 оны 11 дүгээр сарын 02-ны өдрийн 23/57 дугаар “Санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийх тухай” албан бичгийг хүргүүлсэн бөгөөд тус байгууллагын 2023 оны 3 дугаар улирлын санхүүгийн тайланд хийсэн завсрын үеийн санхүүгийн тайлангийн аудитаар алдаа, зөрчил илрээгүй болно.

4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар нийт 2,458.1 мянган төгрөгийн зөрчил илэрснээс цахим баримтаар баталгаажуагүй 1,192.0 мянган төгрөгийн худалдан авалтыг гүйцэтгэж бүртгэсэн, цалин, НДШ-ийн 1,226.1 мянган төгрөгийн өр төлбөр үүсгэсэн зөрчилд 2 албан шаардлага өгөгдсөн байна.

Өмнөх оны аудитаар өгөгдсөн албан шаардлага, зөвлөмжийн биелэлтийг нотлох баримттай тулган баталгаажуулахад 100 хувийн биелэлттэй байна.

Хүснэгт 4 Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Акт	-	-	-	-	-
Албан шаардлага	2	2,458.10	2	2,458.10	100.0
Зөвлөмж					100.0
Нийт дүн	2	2,458.10	2	2,458.10	100.0

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар дараах асуудлуудыг анхааран авч үзэх нь зүйтэй. Үүнд:

1. Дээд шатны төсөв захирагчаас төсвийг зардлын эдийн засгийн ангиллаар нь бус "бараа үйлчилгээний бусад зардал" гэсэн ангиллаар бөөнд нь тусган, төлөвлөж, баталж байгаа нь төсвийг зардлын бүлэг, зүйлээр төлөвлөж, зарцуулах, зарцуулалтад хяналт тавих зарчмыг алдагдуулж байна. Иймд төсвийг бодит гүйцэтгэлтэй нь уялдуулан зардлын бүлэг, зүйл бүрээр төлөвлөж, зарцуулан гүйцэтгэж байх шаардлагатай байна.

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нягтлан бодох бүртгэлийн бичилт, тооцоолол болон тайлагналын дараах **6,080.5** мянган төгрөгийн алдааг залрууллаа. Үүнд:

1. Орлого үр дүнгийн тайланд бараа үйлчилгээний зардлын 2,559.5 мянган төгрөгөөс 2,143.5 мянган төгрөгийг бичиг хэргийн зардлаар, 416.0 мянган төгрөгийг шатахууны зардлаар буруу ангилан тайлагнасан,
2. Орлого үр дүнгийн тайланд 1,000.0 мянган төгрөгийн проектор, 2,521.0 мянган төгрөгийн тоглоом зэрэг нийт 4,541.0 мянган төгрөгийн хөрөнгүүдийг шууд зардлаар тус тус тайлагнасан байна. Эдгээр нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1-д "Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно" гэсэн заалтыг зөрчсөн байна.

Аудитаар нийт **4,218.3** мянган төгрөгийн 3 зөрчил¹ илэрч 2,380.4 мянган төгрөгийн зөрчилд төлбөрийн акт тогтоон, 1,837.9 мянган төгрөгийн 2 зөрчилд албан шаардлага хүргүүлээ.

5.1 Төлбөрийн акт

1. Багшийн гүйцэтгэлийн үнэлгээгээр шалгуур хангаагүй 10 багшид 2,380.4 мянган төгрөгийн улирлын ажлын үр дүнгийн мөнгөн урамшуулал олгосон байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 6.4.1-д "Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", Засгийн газрын 2022 оны 252 тогтоолын 4.4 дэх "Төрийн болон орон нутгийн өмчийн цэцэрлэг, ерөнхий боловсролын сургуулийн багшид мөнгөн урамшуулал олгоход ... **ажлын гүйцэтгэл, үр дүнг** үнэлж, уг урамшуулалд зориулан батлагдсан тухайн жилийн төсөвт багтаан олгоно", БШУС-ын 2022 оны А/430 дугаар тушаалын нэгдүгээр хавсралтаар баталсан Хүүхдийн цэцэрлэгийн багшийн ажлыг үнэлэх, дүгнэх журмын 1.4-т "Багшийн ажлын үнэлгээний үр дүн нь багшид улирлын мөнгөн урамшуулал олгох үндэслэл болно" гэсэн заалтууд болон тус журмын 4.4-д заасан хувь хэмжээг зөрчсөн байна.

¹ Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

Шийдвэрлэсэн нь: Үндэслэлгүй олгосон урамшууллыг нөхөн төлүүлэх төлбөрийн акт тогтоох

5.2 Албан шаардлага

1. Бараа, ажил үйлчилгээний зардлаас урсгал засварын зардалд 1,268.0 мянган төгрөгийг зардлын бүлэг хооронд гүйлгэн, зориулалт бусаар зарцуулж, гүйцэтгэлийг бодитоор тайлагнаагүй байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5 дахь “Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1 дэх “Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно” гэсэн заалтуудыг болон Сангийн сайдын 2021 оны 190 дүгээр тушаалын хавсралтаар батлагдсан “Зардлын эдийн засгийн ангилал ашиглах зааврын”-ыг тус тус зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулж, санхүүгийн тайланг анхан шатны баримтад үндэслэн үнэн зөв илэрхийлж байх албан шаардлага хүргүүлэх,

2.Нэг хүүхдэд ногдох хоолны зардлын нормативыг 569.9 мянган төгрөгөөр хэтрүүлсэн байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д “Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж зарцуулах”, Засгийн газрын 2019 оны “Хоолны зардлын норматив тогтоох тухай” тухай 450 дугаар тогтоолын 1-д 1. “Цэцэрлэгийн хүүхэд бүрийн нэг өдрийн хоолны зардлыг 8-10 цагаар ажилладаг цэцэрлэгт 2475 (хоёр мянга дөрвөн зуун далан таван) төгрөгөөр” гэж заасныг тус тус зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Тогтоосон норм нормативыг мөрдөж ажиллах албан шаардлага хүргүүлэх,

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Залруулсан		Залруулаагүй		Тоо	Дүн
							Тоо	Дүн	Тоо	Дүн		
Зардлын ангиллыг буруу тайлагнасан	1	2,559.5			1	2,559.5	1	2,559.5				
Үндсэн хөрөнгийг шууд зардлаар тайлагнасан	1	3,521.0			1	3,521.0	1	3,521.0				
Дүн	2	6,080.5			2	6,080.5	2	6,080.5				

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Гүйцэтгэлийн үнэлгээнд хамрагдаагүй багшид үр дүнгийн урамшуулал олгосон	1	2,380.4	1	2,380.4								
Зардлын бүлэг хооронд гүйлгэн зарцуулж, гүйцэтгэлийг бодитой тайлагнаагүй	1	1,268.0			1	1,268.0						
Хоолны норматив хэтрүүлсэн	1	569.9			1	569.9						
Дүн	3	4,218.3	1	2,380.4	2	1,837.9						

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил								
Шилэн дансны цахим санд 12 мэдээллийг хугацаа хоцроосон	1	-					1	-
Дүн	1						1	
Бусад хууль тогтоомжийн хэрэгжилттэй холбоотой зөрчил								
Худалдан авах ажиллагааг хуулийн дагуу зохион байгуулаагүй	1						1	
Дүн	1						1	
Нийт дүн	2						2	